



Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
Судалгааны Институт

НООЛУУРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

2021 оны 11 сар
Улаанбаатар хот

АГУУЛГА

ТОВЧ ДҮГНЭЛТ	2
1. Монгол улсын ноолуурын үйлдвэрлэл	3
2. Монгол улсын ноолуурын экспорт ба дэлхийн зах зээл.....	5
3. Ноолуурын үнэ	7
НОМ ЗҮЙ:.....	9

ТОВЧ ДҮГНЭЛТ

1. Монгол улс 2020 онд ойролцоогоор 11.8 мянган тонн ба өмнөх оноос 8.3 хувиар илүү ноолуур бэлтгэсэн. Монгол улсын самнасан ноолуурын үйлдвэрлэл 2015-2018 онуудад тогтвортой жилд дунджаар 16.7 хувиар өсөж байсан бол 2018 оноос хойш жилд дунджаар 33 хувиар буурчээ.
2. Монгол улс 2020 онд үнийн дүнгээр нийт 219.5 сая ам.долларын ноолууран бүтээгдэхүүн экспортолсон ба энэ нь улсын нийт экспортын 2.9 орчим хувийг бүрдүүлж, үнийн дүнгээр өмнөх оны мөн үеэс 38.2 хувиар буурчээ. Монгол улсын ноолууран бүтээгдэхүүний экспортын бүтцийг үнийн дүнгээр авч үзвэл 84.4 хувийг угаасан ноолуур, 7.7 хувийг самнасан ноолуур, 7.9 хувийг сүлжмэл, нэхмэл ноолууран бүтээгдэхүүн эзэлж байна.
3. 2020 онд дэлхийн угаасан болон самнасан ноолуурын нийт импорт үнийн дүнгээр ойролцоогоор 46 хувиар агшсан байна.
4. Монгол улсын ноолуурын экспортын дундаж үнийг тооцож үзвэл 2020 онд өмнөх онтой харьцуулахад угаасан ноолуурын үнэ 41.3 хувиар, самнасан ноолуурын үнэ 19.9 хувиар буурсан байна. Харин 2021 онд дэлхийн зах зээлд ноолуурын үнийн индекс өмнөх оноос 47.8 пунктээр өссөн. Мөн дотоодын зах зээлд ноолуурын дундаж үнэ 93 хувиар өсжээ.


1. Монгол улсын ноолуурын үйлдвэрлэл

Монгол улс 2020 онд ойролцоогоор 11.8 мянган тонн ноолуур бэлтгэсэн ба энэ нь 2019 оноос 8.3 хувиар өсжээ. 2019 оны байдлаар нийт түүхий ноолуур бэлтгэлийн 50 орчим хувийг Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Өмнөговь, Дундговь, Хөвсгөл аймгууд бүрдүүлдэг байна.

Монгол улсын сүүлийн 5 жилийн ноолуурын үйлдвэрлэлийг харвал 2015-2018 онуудад жилд дунджаар 7.3 хувиар өсөж, 2018-2019 онуудад тогтвортой байж, 2020 онд эргээд 7.8 хувиар өссөн байна. Харин 2020 онд Монгол улсын хэмжээнд 27.7 сая толгой ямаа тоологдсон байна. Энэ нь 2019 оны тооллогоос 5.3 хувиар буурсан үзүүлэлт юм.

(Зураг 1)

Зураг 1. Монгол улсын нийт ноолуурын үйлдвэрлэл, ямааны тоо (жилээр, мянган тонн)




/Эх сурвалж: <https://www.1212.mn/>

Ноолууран бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхдээ угаах, самнах, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэсэн үндсэн 3 үе шатыг дамждаг. (Зураг 2)

Монгол улсад ноолуур боловсруулах салбарт 15 гүн боловсруулах үйлдвэр, 23 анхан шатны боловсруулах үйлдвэр, 59 сүлжмэлийн жижиг дунд үйлдвэр, 150-200 өрхийн жижиг цех үйл ажиллагаа явуулж байна.¹

Зураг 2. Ноолуур боловсруулах үйл явц




/Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам/

2020 онд Монгол улс нийт 516.7 тонн самнасан ноолуур үйлдвэрлэсэн ба энэ нь 2018-2019 онуудад жилд дунджаар 33 хувиар буурсан дүнтэй байна. Харин 2015-2016 онд самнасан ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээ тогтвортой, 2017-2018 онуудад жилд дунджаар 16.7 хувиар өсөж байжээ. (Зураг 3).

¹ ХХААХҮЯ

Зураг 3. Монгол улсын нийт самнасан ноолуурын үйлдвэрлэл (жилээр, тонн)



/Эх сурвалж: <https://www.1212.mn/>

2020 онд Covid-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэл нь тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүн болох ноолууран бараа, бүтээгдэхүүн болон түүний боловсруулах салбарт томоохон цохилт болсон.

Цар тахлын нөлөөгөөр аж ахуйн нэгж, өрхийн орлого буурсан, хэрэглэгчдийн худалдан авах зан төлөв өөрчлөгдсөн, улс хоорондын зорчих хөдөлгөөн хязгаарлагдан жуулчлалын тоо багассан зэргээс шалтгаалан дотоод худалдан авалт буурах, түүнчлэн хил дээр ачаа тээврийн гацаа үүсэж гадаад борлуулалт буурах зэргээр ноолууран бүтээгдэхүүний эрэлт ерөнхийдөө багассан байна. Монгол улсын ноолуурын салбарын хамгийн том ААН-д тооцогдох “Говь ХК” 2020 оны тайландаа дотоод зах зээл дэхь борлуулалтын хэмжээ өмнөх оныхтой харьцуулахад 63 хувиар, гадаад зах зээл дэхь борлуулалтын хэмжээ 45 хувиар буурсан гэж мэдээлсэн байна.


2. Монгол улсын ноолуурын экспорт ба дэлхийн зах зээл

Монгол улсын ноолуурын экспорт

Монгол улс 2020 онд нийт 219.5 сая ам.долларын ноолууран бүтээгдэхүүн экспортолсон ба энэ нь улсын нийт экспортын ойролцоогоор 2.9 хувийг бүрдүүлж байна.

Монгол улс нийт ноолуурын экспортын бүтцийг үнийн дүнгээр авч үзвэл 84.4 хувийг угаасан ноолуур (185.3 сая ам.долларын дүнтэй), 7.7 хувийг самнасан ноолуур (16.9 сая ам.доллар дүнтэй) эзэлж байгаа бол дөнгөж 7.9 хувь (16.9 сая ам.долларын дүнтэй) сүлжмэл, нэхмэл ноолууран бүтээгдэхүүн экспортолжээ. (Зураг 4)


Зураг 4. Монгол улсын угаасан болон самнасан ноолуурын экспортын хэмжээ (жилээр)



/Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар/

Харин ноолууран бүтээгдэхүүний экспортыг тоо хэмжээгээр нь авч үзвэл 2020 онд ойролцоогоор 6.3 сая кг угаасан ноолуур, 260 мянган кг самнасан ноолуур, 314 мянган ширхэг сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн экспортолсон байна. (Зураг 5)

Зураг 5. Монгол улсын нийт нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүний экспорт (жилээр)



/Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар/

Угаасан ноолуурын экспортын хэмжээ 2016 оноос 2018 оны хооронд харьцангуй тогтмол байжээ. Харин самнасан ноолуурын экспортын хэмжээ 2016-аас 2018 он хүртэл жилд дунджаар 14 хувиар, бэлэн бүтээгдэхүүний экспортын хэмжээ 2016-аас 2019 он хүртэл

жилд дунджаар 42.3 хувиар тогтвортой өссөн байна (Зураг 5,6). 2018-аас 2020 оны хооронд угаасан ноолуурын экспортын хэмжээ нийт 19.9 хувиар өсөж, самнасан ноолуурын экспортын хэмжээ 60.7 хувиар буурсан байна. Мөн 2020 онд бэлэн бүтээгдэхүүний экспортын хэмжээ 21.9 хувиар буурчээ.

Монгол улс 2020 онд угаасан ноолуурын 99.9 хувийг БНХАУ-д улсад, самнасан ноолуурын 80.9 хувийг Итали, 6.4 хувийг Их Британи, 5.3 хувийг Герман, 4.9 хувийг Өмнөд Солонгос, 2.4 хувийг Энэтхэг, үлдсэн 0.1 хувийг АНУ, Испани, Франц, Япон зэрэг улсуудад, нэхмэл болон сүлжмэл бүтээгдэхүүнийг Америк, Герман, Солонгос, Япон, Бельги, Франц зэрэг 20 гаруй улсуудад экспортолсон байна.

Дэлхийн зах зээл

Дэлхийн ноолуур бэлтгэлийн ойролцоогоор 40 орчим хувийг Монгол улс, 48 хувийг БНХАУ, үлдсэн 12 хувийг Иран, Афганистан гэх мэт орнууд бүрдүүлдэг байна². Дэлхийн ноолуурын зах зээлийн 90 орчим хувийг нийлүүлэгч Монгол, БНХАУ-ын ноолуурууд цаг уур, удамшил, ноолуур хураах арга барилаас шалтгаалан хоорондоо ялгаатай байдаг. Монгол ноолуур илүү урт ширхэгтэй, бохирдол бага, нэг ямаанаас өгөөж их мөн байгалиасаа олон өнгөтэй байдаг тул өнгө оруулагч будаг хэрэглэх шаардлагагүй байдаг байна. (Хүснэгт 1).


Хүснэгт 1. Монгол, БНХАУ-ын ноолуурын ялгаа

Гол үзүүлэлтүүд	Монгол ноолуур	БНХАУ-ын ноолуур
Гарц	Нэг ямаанаас 350 гр	Нэг ямаанаас 200 гр
Бохирдол	20-25%	25-30%
Диаметр	16.5 микрон	15.5 микрон
Урт	42-45 мм	36-38 мм
Өнгө	Байгалийн 4 өнгөтэй	99% нь цагаан өнгийн ноолуур байдаг

/Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам/

Олон улсын худалдааны төвийн гаргасан статистик мэдээнд 2020 онд дэлхийн угаасан ноолуурын хамгийн том импортлогч улсууд Итали, Их Британи, Өмнөд Солонгос, Герман, Япон зэрэг улсууд байна. Харин самнасан ноолуурын хувьд Мадагаскар, Итали, Өмнөд Солонгос, Босни ба Герцеговин болон Норвеги зэрэг улсууд хамгийн их самнасан ноолуур импортолсон байна. (Зураг 6).

Зураг 6. 2020 онд угаасан болон самнасан ноолуур хамгийн их импортолсон орнууд



/Эх сурвалж: <https://www.trademap.org/>

Олон улсын худалдааны төвийн статистикаас харвал 2020 онд дэлхийн угаасан болон самнасан ноолуурын импорт ойролцоогоор 46 хувиар агшсан. Мөн 2020 онд Монгол улсын нийт экспортолсон ноолууран бүтээгдэхүүн үнийн дүнгээр 38.2 хувиар буурчээ.


² ХХААХҮЯ

3. Ноолуурын үнэ

Монгол улсын Хөдөө аж ахуйн биржийн мэдээлж байгаагаар 2021 оны 6 сараас 11 сарын хооронд боловсруулаагүй түүхий ноолуурын үнэ 1 кг нь 115 мянган төгрөгөөс 140 мянган төгрөгийн хооронд хэлбэлзсэн байна.

Гаалийн ерөнхий газрын мэдээгээр ноолуурын экспортын дундаж үнийг тооцож үзвэл 2020 онд угаасан ноолуур дунджаар нэг кг нь 29.2 ам.доллар буюу 2020 оны Монголбанкны албан дундаж ханшаар тооцвол 82.1 мянган төгрөг, самнасан ноолуур дунджаар 64.9 ам.доллар буюу 182.6 мянган төгрөгтэй тэнцэж байна. Энэ нь 2019 онтой харьцуулахад угаасан ноолуурын үнэ 41.3 хувиар, самнасан ноолуурын үнэ 19.9 хувиар буурсан дүнтэй байна. (Зураг 7).

Зураг 7. Угаасан болон самнасан ноолуурын экспортын жилийн дундаж үнэ




/Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар/

Covid-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн хэмжээнд тансаг зэрэглэлийн бараа, бүтээгдэхүүний эрэлт буурсан нь 2020 онд ноолууран бүтээгдэхүүн, түүний түүхий эдийн үнэ буурахад нөлөөлжээ. Дэлхийн хамгийн том ноолуур импортлогчдын нэг болох Итали улсын угаасан болон самнасан ноолуурын нийт импорт үнийн дүнгээр 2020 онд өмнөх оноос 36.7 хувиар буурсан байна.

Харин 2021 онд Covid-19-ийн нөлөө сулрахыг дагаад ноолуурын үнэ өссөн дүр зураг ажиглагдаж байна. Тухайлбал Италийн Шнейдер группийн гаргадаг ноолуурын зах зээлийн үнийн индикатор³ нь 2020 оны 7-р сард 82.2 байсан бол 2021 оны 7 сард 130 болж 47.8 пунктээр өсжээ (Зураг 8).

³ Дэлхийн түүхий ноолуурын гол нийлүүлэгч Монгол, БНХАУ, Иран улсуудын ноолуурын үнийн индексийн дундаж утга


Зураг 8. Шнейдер группээс гаргадаг Монгол, Иран, БНХАУ-ын ноолуурын үнийн индикатор



/Эх сурвалж: <https://www.gschneider.com/>

Мөн Монгол улсын дотоодын зах зээлийн үнийг авч үзвэл 2020 оны 6-7 сард боловсруулаагүй бараан, цайвар, цагаан ноолууруудын дундаж үнэ 64.7 мянган төгрөг байсан бол 2021 оны 7 сард 124.7 мянган төгрөг болж энэ хугацаанд дунджаар 93 хувиар өсжээ. (Зураг 9)

Зураг 9. ХААБ-ийн мэдээлсэн боловсруулаагүй бараан ноолуурын үнэ



/Эх сурвалж: Хөдөө аж ахуйн бирж/

НОМ ЗҮЙ:

- ХХААХҮЯ-ны цахим хуудас:
<https://mofa.gov.mn/exp/blog/11/175>
<https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/noos2020.pdf>
- ҮСХ-ны цахим хуудас:
<https://1212.mn/>
- Гаалийн ерөнхий газар, Гадаад худалдааны статистик мэдээллийн систем:
<https://www.customs.gov.mn/statistics/>
- International Trade Center, Trade statistics for international business development:
<https://www.trademap.org/Index.aspx>
- “Говь ХК”, 2020 оны жилийн тайлан:
<https://cdn.shopify.com/s/files/1/1953/2845/t/109/assets%2F2020.pdf>
- ХААБ, Арилжааны үнийн статистик:
<http://www.mce.mn/trade>
- The Schneider Group, Cashmere market indicator:
<https://www.gschneider.com/cashmere-and-silk-market-indicators/>